

06 дүгээр сарын үйл ажиллагааны мэдээ**Нэг. Удирдлага, зохион байгуулалтын талаар****Төрийн үйлчилгээний чиглэлээр:**

ЗДТГ-т Чанарын менежментийн тогтолцоо ISO 9001:2015 стандарт хэрэгжиж буйтай холбогдуулан ЗДТГ-ын мэдээллийн самбар болон Munkhkhaan.su.gov.mn нэгдсэн вэб сайтад байгууллагын эрхэм зорилго, алсын хараа, чанарын бодлого, зорилт, үнэт зүйл зэргийг иргэдэд ил харагдахаар байршуулж тамгын газрын албан хаагчид эрхэм зорилго алсын хараа үнэт зүйлсээ бүгд өрөө тасалгааны хананд тавьж өдөр тутам хэрэгжилтийг ханган ажиллаж байна. ЗДТГ-т Чанарын менежментийн тогтолцоо ISO 9001:2015 стандарт хэрэгжиж буйтай холбогдуулан ЗДТГ-ын мэдээллийн самбар болон Munkhkhaan.su.gov.mn нэгдсэн вэб сайтад байгууллагын эрхэм зорилго, алсын хараа, чанарын бодлого, зорилт, үнэт зүйл зэргийг иргэдэд ил харагдахаар байршуулж тамгын газрын албан хаагчид эрхэм зорилго алсын хараа үнэт зүйлсээ бүгд өрөө тасалгааны хананд жаазалж байршуулсан.

Чанарын менежментийн тогтолцоо ISO 9001:2015 стандартын анхдагч баталгаажуулалт авах бэлтгэл ажлын хүрээнд тамгын газрын албан хаагчдын бичиг хэргийн хавтас авах, ISO самбарыг шинээр хийх болон тамгын газрын үүдний угталтын тохижилтын ажлыг хийж тамгын газрын төсвөөс 4500,0 мян төгрөгийн зардлыг гаргаж ажилласан. 2022 оны 06-р сарын 23-24 ны өдрүүдэд ISO 9001:2015 Анхдагч баталгаажуулалтын аудитыг хамрах хүрээ төрийн үйлчилгээгээр онлайнаар Монсертф ХХК –ны тэргүүлэх аудитор Ц.Мөнхзул хөндлөнгийн аудитор Баасандорж нар анхдагч баталгаажуулалтын аудитыг хийсэн. Анхдагч баталгаажуулалтын аудитад тамгын газрын дарга, чанарын менежер чанарын хорооны гишүүд, тамгын газрын албан хаагчид хамрагдан амжилттай хамгаалсан.

Хоёр: Нийгмийн бодлогын хүрээнд

Нэг өрх нэг байгууллага аяны хүрээнд 2-р багийн 1 залуу өрхийг дэмжиж малжуулах төсөлд хамруулахаар шийдвэрлээд байна. Хамтарсан багийн зүгээс Хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулсан туршилтын 10 өрхийн 18 хүүхэд, бүтэн өнчин 1 хүүхдэд гарын бэлэг өгсөн.

НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ЧИГЛЭЛЭЭР

Хүнсний эрхийн бичгийн үйлчилгээнд 32 өрхийн 149 иргэн хамрагдаж 1744,0 мян төгрөгийн санхүүжилт олгогдоод байна.

ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ЧИГЛЭЛЭЭР

Аж ахуй эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн хүрээнд 2 иргэн 19,0 сая төгрөг, ХБИ –ийг дэмжих хөтөлбөрийн хүрээнд 1 иргэн 7,0 сая, малжуулах арга хэмжээнд 6 иргэн

30,0 сая, гэрээт малчинд 1 иргэн 5,0 сая, төгрөгийн дэмжлэг Ногоон ажлын байр хөтөлбөрийн хүрээнд нийтийг хамарсан ажлаар 10 иргэн, мод тариалах ажилд 20 иргэн хамрагдсан.

Нийгмийн даатгал: Өндөр насны тэтгэвэрт 4 иргэн тогтоолгосон. Мөн 0-3 хүртэлх насны хүүхдээ асарч байгаа эхийн даатгалд шинээр 2 эхийг хамруулсан. Жирэмсэн болон амаржсаны 6 эхэд тэтгэмжийг өөрийн хүсэлтийн дагуу өөрийнх нь дансанд шилжүүлсэн. Эрүүл мэндийн даатгалд 25 иргэн даатгуулж төвлөрсөн харилцах дансанд мөнгийг хийлгэж программд шивсэн. Сумын орон тооны бус зөвлөлд 2 малчны материал ирсний дагуу шалгаж 1 малчныг хурлаар хэлэлцэн малчнаар ажиллаж байсанд тооцож хурал хийсэн.

ЕБС: Орон нутгийн өмчийн эд хөрөнгийн улсын үзлэг, тооллогын комиссын бүрэлдэхүүн тооллогоо амжилттай хийж дуусгалаа.

12-р ангийн төгсөгчид 7 хичээлээр давхардсан тоогоор 135 сурагч ЭЕШ өгсөн бөгөөд Хими, Математик, Монгол хэл гэсэн хичээлүүд улсын дунджаас дээгүүр шалгагдсанд үнэлэгдээд байна. Сумын ҮЭ –ийн холбооноос зохион явуулсан Гарбөмбөгийн тэмцээнд сургуулийн баг тамирчид хамт олноо төлөөлөн амжилттай оролцож 3-р байр эзлэв.

“Энтрепренершип боловсрол олгох” төсөл 2021 оноос эхлэн амжилттай хэрэгжиж төслийн хүрээнд 5 ментор багш чиглүүлж, 8-12-р ангийн 118 сурагч, насанд хүрэгчийн 14-25 насны 12 залуучууд төгсөж нийт 7 төсөл дэмжигдэн 2.8 сая төгрөгний санхүүжилтийг 2 төсөл аваад байна. Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2010 оны 63 дугаар зарлиг, 2021 оны 58 дугаар зарлигаар "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөнд нэгдэж байгууллагын гадна талбайд 114 мод суулгалаа. Мөн ногоон байгууламжинд 70 суулгасан. Хүүхдийн эрхийг хамгаалах өдрөөр байгууллагын 89 багш, ажилчдын 135 хүүхдүүдэд 2 сая төгрөгний бэлэг гардуулан өглөө.

Соёл: Сүхбаатар аймгийн Урлаг соёлын арга хэмжээнд сумаас 33 уран бүтээлчид оролцож Улаанбаатар хотод зохион байгуулагдсан Талын монгол тоглолтонд оролцсон.

ГУРАВ: ТӨСӨВ САНХҮҮГИЙН ЧИГЛЭЛЭЭР:

Санхүү алба нь сарын хувиарын дагуу 6 сарын 1-6 ны хооронд төсөвт байгууллагын 5-р сарын төсвийн гүйцэтгэлийн мэдээг гарган хянан баталгаажуулж ажиллалаа. Мөн дээрх хугацаанд төсвийн орлого зарлага, бүтэц орон тоо, төсвийн хувиарын дагуу олгогдсон санхүүжилт, 5 саяаас дээш гүйлгээ, өр авлагыг www.shilendans.mn сайт руу шивж ил тод байдлыг мэдээллэсэн. Орон нутгийн өмчийн газраас ирсэн захирамжийн дагуу Сумын засаг даргын А/96 тоот захирамж, Сумын засаг даргын тамгын газрын даргын А/16 тоот тушаалуудыг гаргаж сумын орон нутгийн өмчийн хөрөнгийн улсын үзлэг тооллогын ажлыг удирдан зохион байгуулах ажлын хэсгийг байгуулж төсөвт байгууллагуудын тооллогыг 6 сарын 15 ны дотор хийж гүйцэтгэж байгууллагын эзэмшилд байгаа ашиглах хугацаа нь дууссан эд хөрөнгө, бараа материал, тоног төхөөрөмжүүдийг газар дээр нь үзэж тоолж актлах болон шинээр худалдан авсан эд хөрөнгийг орлогодож авч бүртгэлжүүллээ. Статистикийн хуулийн 7-р зүйлд заасны дагуу Үндэсний статистикийн хороо нь хөдөө аж ахуйн улсын тооллогыг Засгийн газрын 2022 оны 74-р тогтоолоор баталсан тов буюу 6 сарын 6-19 ны хооронд багийн засаг дарга ХААТасагтай хамтран мал аж ахуй, газар тариалан, ойн аж ахуйн үйлдвэрлэл эрхэлдэг аж ахуйн нэгж, иргэд буюу сумын нийт өрхийн 30%, 384 өрх 2 аж ахуйн нэгж хамрагдлаа. 6 сарын 20-30 хүртэл төсөвт 6 байгууллагуудын цалин хөлс, бусад тогтмол зардал бичиг хэрэг тээвэр шатахуун зэрэг зардалын гүйлгээг хийж гүйцэтгэлээ

Эрүүл мэндийн чиглэлээр:

2022 оны 06 сарын 29-ны байдлаар 38 өвчтөн хэвтэн эмчлүүлсэн. Үүний 26 насанд хүрэгчид, 12 хүүхэд хэвтэн эмчлүүлсэн.

ОУ-ын Ротари сангийн санхүүжилтээр “Элэгний В,С вирус, элэгний хавдар илрүүлэх гепатитгүй монгол төсөл”-ийн хүрээнд манай суманд ХӨСҮТ, Интермэд эмнэлэг, УКТЭмнэлгийн эмч нарын үзлэг оношлогоо 2 өдөр хийсэн.

Энэ үзлэг шинжилгээнд хамрагдвал зохих 315 хүнд утсаар мэдээлэл өгч дуудан ирүүлж үзлэг, оношлогоо хийлгэсэн. Энэ үзлэгээр 921 хүн /давхардсан тоогоор/ үзлэг шинжилгээнд хамруулсан. 397 хүн В,С вирусын шинжилгээнд хамрагдаж В вирустай 43 хүн, С вирустай 14 хүнд илэрснийг идэвхжил тоолуулах эмчилгээ хийлгэх талаар зөвлөгөө өгсөн. ЭХО үзлэгт 251 хүн хамрагдаж 137 хүн буюу 54,5% нь элэгний эмгэг илэрлээ. Эмчийн үзлэгт 177 хүн үзүүлж зөвлөгөө, эмчилгээ авч дараагийн шатлалд 5 хүн илгээлээ. Элэгний хатуурлын оношлогоо 96 хүнд хийгдэж 67 хүн буюу 69,7% нь элэгний хатууралтай гэж оношлогдсон.

Шинээр 18 нас хүрсэн өмнө нь шинжилгээнд хамрагдаагүй 12 хүүхдээс шинжилгээ авч “Вируст гепатитийн халдвараас хэрхэн сэргийлэх” мэдээлэл өгч гарын авлага тараасан.

Манай ЭМТөв нь элэгний эмгэг болон В,С вирустай зорилтот бүлгийн хүмүүсээ энэ үзлэг шинжилгээнд хамруулж оношлогоо, эмчилгээ, хяналт, зөвлөмж өгч ажиллалаа.

- Гепатитын С вирус
- Элгээ хайрлацгаая
- Элэгний хавдар
- Гепатитийн В вирус
- Элэгний хатуурал зэрэг гарын авлага 250ш иргэдэд тарааж мэдээ мэдээллийг өгсөн.

Амбулаторийн үзлэг 462, урьдчилан сэргийлэх үзлэг 137 байна.

Түргэн тусламжийн дуудлага 68 ирснээс алсын дуудлага–24, ойрын дуудлага 44 ирсэн байна. Дуудлагыг цаг тухай бүрд нь барагдуулсан.

Дөрөв : Мал эмнэлэгийн болон ХХАА-н чиглэлээр:

ХААТ: 2022-06-07ны өдрөөс 2022-06-17 өдрийг хүртэл орон даяар зохион байгуулсан ХАА-н болон хагас жилийн мал тооллогын ажлыг зохион байгуулж ажиллалаа. Тооллогын ажилд 5- н багт багийн засаг дарга нар болон тамгын газрын мэргэжилтэн нийт 9 хүн оролцож ажилласан. ХАА-н болон мал тооллогын түүвэрт нийт мал бүхий өрхийн 30% буюу 384 өрх тооллогонд хамрагдсанаас: МАА-н түүвэр судалгаанд-2 аж ахуйн нэгж, 350 өрх, газар тариалангийн судалгаанд-30 өрх, 2 аж ахуйн нэгж тооллогод бүрэн хамрагдаж мэдээ тайланг цаг хугацаанд нь хүргүүлж ажилласан. ОНХС-ийн хөрөнгө оруулалт 50,0 сая төгрөгөөр ногоон байгууламж усжуулах зорилгоор 1 гүн өрмийн худаг, бэлчээр усжуулах зорилгоор-1 гүн өрмийн худагыг тус тус “Оргилон дэлгэрэх сүм” ХХЗ-тай гэрээ хийж гаргах үйл явцад хяналт тавьж ажиллалаа. Дорнод монголын хуурай хээрийн тогтвортой ландшафт биологийн олон янз байдал төслийн газраас” Ноосны зах зээл” өдөрлөгийн хүрээнд Баянцагаан багийн төвд цахилгаан машинаар хонь хяргах үзүүлэх сургууль зохион байгуулж 5 багийн 20 иргэн оролцож 2 иргэн хонь хяргах дадал эзэмшиж сертофикат авсан.

МЭТ: 2022 оны 06 дугаар сарын 20-22-ны өдрүүдэд Сүхбаатар аймгийн мал эмнэлгийн газраас зохион байгуулсан сургалтанд мал эмнэлгийн тасаг, нэгжүүдээс 4 эмч оролцож мал эмнэлгийн нэгдсэн системийн сайжруулалтын МЭНС-2 хэрэгжүүлэх бэлтгэл ажлыг хангах, оролцооны эпидемилогийн чиглэлийн сургалтанд хамрагдаж хагас жилийн тоон болон бичмэл тайланг гарган Мал эмнэлгийн газарт тайлагнасан.

2022 оны 06 дугаар сарын байдлаар нийт **390,0** мянган м/кв талбайд халдваргүйтгэлийг хийхээр төлөвлөснөөс 18 түүхий эдийн цэгийн 12,0 мян м/кв, 112 хашаа хорооны 80,0 мянган м/кв, 25 худаг уст цэгийн 5,9 мянган м/кв, нийтийн эзэмшлийн 10,1,2 мянга м/кв, бэлчээрийн 8,8 мянга м/кв, 6 устгалын цэгийн 5,6 мянган м/кв, өтөг бууцны 78,4 мянган м/кв, нийт 201,8 мянган м/кв талбайд халдваргүйтгэлийг хийгээд байна. Сүхбаатар аймгийн хот тохижуулах газраас 2 удаа хүн авчирч эзэнгүй золбин 285 нохойг устган хогийн цэгт булж, халдваргүйтгэлийг хийсэн.

Сумын Засаг даргын 2022.05.11-ны өдрийн А/87 тоот захирамжаар гоц халдварт үхрийн арьс товруутах өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцинжуулалтыг 2022.04.12-ны өдрөөс эхлэн 06.03-ыг хүртэлх хугацаанд 709 өрхийн 35478 толгой үхэр, 12090 толгой тугал, нийт 47568 малыг хамруулж 47568 тун вакцин зарцуулж, хэвийн хорогдолд 432 тун вакциныг устгаж вакцинжуулалтын мэдээг нэгтгэн Мал эмнэлгийн газарт хүргүүлээд байна.

Малын гоц халдварт шүлхий өвчний вакцинжуулалтын дархлааны идэвхийг шалгах тандалт шинжилгээг 3 өрхийн 18 үхрээс цусны дээжийг авч лабораторид хүргүүлээд байна.

Үхрийн арьс товруутах өвчнөөс урьдчилан сэргийлэх асуумж судалгааг утсаар 5 багийн 49 өрхөөс авч заавар зөвлөмжийг өгөөд байна.

ХАА төслөөс хэрэгжүүлж байгаа хонь ноослох ажилд оролцож ноосолсон хонийг угаалганд хамруулах үзүүлэх сургалтыг “Буман төл” мал эмнэлгийн үйлчилгээний нэгжтэй хамтран зохион байгуулсан

Тав : Байгаль орчин газар зохион байгуулалтын чиглэлээр:

Мөнххаан сумын Баян-уул 2-р багийн “Цагаан булаг”-ийг хашиж хамгааллахад 10 хоног бэлтгэл ажлыг ханган ажиллаж хийж гүйцэтгэсэн.

Амжиргааны түвшин доогуур орлоготой өрхийн 10 иргэнийг өдрийн 36.000 төгрөгөөр нийт 360.000 төгрөгөөр цалинжуулан ажиллаж мөн багийн иргэдийн заавар зөвлөмжийг үндэслэн булаг хашиж хамгаалах ажлыг гүйцэтгэсэн.

Хэнтий аймгаас нийт 4м-ийн 24 ширхэг турба 960000 төгрөг, Турбо м150-ын 8ш 240000 төгрөг, Цемент 5уут 75000 төгрөг, тээврийн хөлс 300000 төгрөг, Шатах тослох материалын 163800 төгрөгийг тус тус зарцуулсан. Цагаан булгийн хашихад 16 эгнээ, 12 шонгоор хашиж хамгаалж байгаа ажлын гүйцэтгэсэн. Мөн хашсан булгийн хог хаягдлыг цэвэрлэсэн. Хагас жилийн байдлаар төсөвт 5 байгууллага 1500 ш мод, 10-н ААН 2073 ш мод, 143 өрх 1070 ш мод нийт шинээр 6643ш мод тариад байна. Ургалт 50 хувьтай байна. МУ-ын Ерөнхийлөгчийн Тэр бум мод хөдөлгөөнийг иргэдэд сурталчилан таниулж Мод тарих, арчлах, ургуулах зөвлөмж болон видео, шторк түгээх ажлыг 5 удаа 3-н группэд мэдээллийг оруулж ажилласан. 200 иргэн хандалт мэдээлэл авсан байна.

Хоёр: Хустайн байгалийн цогцолборт газрын Жаргалантын ам хэмээх газраас 3-р багийн нутаг Мөнххаан ууланд 50 тооны монгол тарвага сэргээн нутагшуулсан. Үүнд орон нутгийн хөгжүүлэх сангаас 20 сая төгрөгийг зарцуулсан.

Газар зохион байгуулалтын чиглэлээр:

Хагас жилийн байдлаар 1 арга хэмжээний 6 нэгж талбарт иргэдээс хүсэлт авч, өргөдлийн дагуу кадастрийн холболт хийн шийдвэрлэх, төлөвлөгөөний биелэлтийг хангаж ажилласан. ГЗТөлөвлөгөөнд тусгагдсан нэгж талбар тус бүрээр газар өмчлөлийн өргөдлийг иргэдээс авч хуулийн дагуу шийдвэрлэж нийт 83 иргэний өмчлөлийн асуудлыг шийдвэрлэлээ. ГЗБТөлөвлөгөөнд тусгагдсан 6 нэгж талбарт газрын дуудлага худалдааг амжилттай зохион байгуулж дууссан. Дуудлага худалдаанд ялсан иргэдтэй гэрээ байгуулах шатанд явж байна.

МЭДЭЭ НЭГТГЭСЭН: ТГ-ЫН МЭРГЭЖИЛТЭН

О.ТУЯА.